



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон. Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
http://www.parliament.mn

2017-12-04 № 16

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
САЙД УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ  
ТАНАА

Асуулга тавих тухай

Сүүлийн үед Монгол Улсад крипто валют буюу цахим мөнгийг хөгжүүлэх, ашиглах, нэвтрүүлэх талаар яриа нийгэмд газар авч олон нийтийн анхаарлыг ихээр татах боллоо. Улмаар цахим мөнгө, биткойн, блокчэйн технологийг нэвтрүүлэх талаар ТББ, холбоод байгуулагдаж энэ талаар тодорхой санаачилга гарган ажиллаж байна.

Нөгөө талд нь цахим мөнгө, блокчэйн технологийн талаар улс төрчид олон янзаар ярьж байр сууриа илэрхийлж байна. Харин уг асуудлын талаар өнөөг хүртэл Монгол Улсын Засгийн газар, Монгол банк, Хууль зүйн, дотоод хэргийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс албан ёсны нэгдсэн байр сууриа илэрхийлээгүй байгаа нь иргэд, энэ төрлийн бизнес эрхлэгчдийн дунд тодорхойгүй байдал, хүлээлт үүсгээд байна.

Гадаад улсуудын олонх нь энэхүү технологийг хориглохгүй харин төрийн хяналттайгаар хөгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Манай улс цахим мөнгө, блокчэйн технологийн талаар цаашид ямар бодлого баримтлах, ялангуяа хөгжүүлэх бол хэрхэн дэмжиж хамтран ажиллах, татварын болон хяналтын ямар тогтолцоо нэвтрүүлэх зэргээ цаг алдалгүй зарлах хэрэгтэй гэж үзэж байна.

Иймд миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасны дагуу бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуулгыг Танд хандан тавьж байна. Үүнд:

1. Монгол Улс цахим мөнгө, биткойн зэргийн талаар ямар бодлого баримталж байна вэ? Энэ талаар төрийн нэгдсэн бодлого боловсруулж байна уу? Цахим мөнгийг хөгжлийн гарааны үед нь ойлгож хүлээн авч хөгжүүлэх, боловсон хүчин бэлтгэх, эрх зүйн орчныг бий болгох бодлогоо цаг алдалгүй тодорхойлон зарлах хэрэгтэй гэж үзэж байна.
2. Блокчэйн технологи нь бизнес, боловсрол, эрүүл мэнд, төрийн захиргаа зэрэг аль ч салбарын үйл ажиллагааг өндөр үр ашиг, хурд, найдвартай, ил тод явуулах боломж олгох, интернетийн дараа гарч ирсэн жинхэнэ “хувьсгал” авчрах технологи гэж мэргэжлийн хүмүүс үзэж байна. Иймд олон жил хэрэгжихгүй удсан “Цахим гарын үсгийн тухай хууль”, “Цахим монгол” хөтөлбөрийг амьдрал дээр бодитойгоор хэрэгжүүлэх боломж, мөн суурь технологи гэж үзэж байгаа тул цаг


0000000025

алдалгүйгээр түүнийг нэвтрүүлэн ашиглах боломжтой байна. Энэ талаар Засгийн газраас ойрын үед ямар арга хэмжээ авах вэ?

Эдгээр асуудлыг Засгийн газар анхааралдаа авч судлан хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан хугацаанд ирүүлж, Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд сонгохыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Н. УЧРАЛ